



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БҮТ

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2024 БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛ

10
АНГИ

МОНГОЛЫН ТҮҮХ

ХУВИЛБАР А

Аймаг / дүүрэг:

Сум / сургууль:

Анги / бүлэг:

Сурагчийн овог:


Сурагчийн нэр:

Сурагчийн код:

САНАМЖ

- Даалгаврыг 40 минутад гүйцэтгээрэй.
- Даалгавар тус бүрээс зөвхөн нэг хариултын хувилбарыг сонгож, хариултын хуудсанд зааврын дагуу балын харандаагаар будаарай.

1. Доорх он тооллын шугамыг ашиглаж палеолитын дээд үеийг тооцоолоорой.



- A. 80000 B. 60000 C. 40000 D. 20000

2. Доорх чулуун зэвсгийн дурсгалт газруудаас палеолитын доод үеийн олдвор олдсон газар вэ?

- A. Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын Шивээт хайрхан
 B. Ховд аймгийн Манхан сумын Хойд цэнхэрийн агуй
 C. Дорнод аймгийн Булган сумын Норивлон уул
 D. Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын нарийн голын хөндийн бууц суурин

3. “Монголын өвөг түүх”-ийн үед холбогдох үечлэл аль нь вэ?

- A. Хятан улсын үе B. Үйлдвэрлэх аж ахуйн үе
 C. Чингисийн эрин үе D. Монголын эзэнт гүрний үе

4. Монгол нутагт амьдарч байсан эртний хүмүүсийн нүүдлийн иргэншилд шилжсэн нь аль үед хамаарах вэ?

- A. Мезолитын үе B. Чингисийн эрин үе
 C. Хүрэл, түрүү төмрийн үе D. Палеолитын үе

5. Мезолитын үеийн он цаг аль нь вэ?

- A. 800.000-12.000 жилийн өмнө B. 12.000-8.000 жилийн өмнө
 C. 8.000-НТӨ III мянган D. НТӨ III мянган – НТӨ IV зуун

6. Цэгийн оронд тохирох нэрийг сонгоно уу?

Сяньби угсааны Муюн улсыг үндэслэгч 285 онд азарганы ноцолдооноос болж ах Түгүхунитэйгээ муудалцан, хөөж явуулсандаа хожим гэмшин, ахаа санан “Ахын дуу”-г зохион дуулсан ажээ. Ах нь албат иргэдээ дагуулан алс баруун зүг нүүж, Хөх нуурт очиж нутаглан улсыг байгуулсан юм.

- A. Модун, Хүннү B. Таньшихуай, Сяньби C. Буман, Түрэг D. Муюн, Тогон

7. Нирун (Жужан) улсыг хэн байгуулсан бэ?

- A. Таньшихуай B. Модунь C. Буман D. Чарагуй

8. Хүннү гүрэн хаан ширээний төлөөх тэмцлийн улмаас бууран доройтож, 48 онд ямар хэсэг болж хуваагдсан бэ?


- A. Баруун ба Зүүн B. Өмнөд ба Умард C. Зүүн ба Өмнөд D. Умард ба Баруун

9. Чингис хаан 1196 онд Татаруудтай хаана тулалдсан бэ?

- A. Улз гол B. Наху Гүн
 C. Онон мөрний хөвөө D. Далан Балжуд

10. Чингис хааны монголын түүхэнд гүйцэтгэсэн үүрэг аль вэ?
А. Монгол угсаатныг нэгэн төрийн жолоонд оруулсан
В. Торгоны замын үүрэг түүхэнд байгаагүй өндөр түвшинд хүрсэн
С. Шашин хоорондын дайн эцэс болсон
D. Өрнө дорныг холбосон эдийн засаг, соёлын харилцааг хөгжүүлсэн
11. Их Монгол улсын харьяат нарыг тонон дээрэмдэж түйвээх болсон тул, 1216 онд Чингис хаан Хар Хятаныг дайлуулахаар хэнийг илгээсэн бэ?
А. Боорчу В. Мухали С. Зэв D. Зэлэм
12. 1269 онд Хубилай хааны зарлигаар Дөрвөлжин бичгийг зохиосон хүн хэн бэ?
А. Аюуш гүүш В. Пагва лам Лодойжалцан
С. Занабазар D. Зая бандида Намхайжамц
13. Түмэн Засагт хааны төр барьсан үе аль нь вэ?
А. 1604-1634 он В. 1557-1592 он С. 1453-1454 он D. 1470-1517 он

14. Цэгийн оронд тохирох үйл явдлыг нөхнө үү.



- А. Түмү-гийн хэрэг, Эрдэнэ зуу хийдийг байгуулав.
В. Түмэн Засагт хаан Гармаа ламыг өргөөндөө залж, багш шавь бололцов. Алтан хан Төвөдөөс Содномжамц ламыг залав.
С. Монголын улс төр төв эх нутагтаа шилжив, Дөчин, Дөрвөн хоёр “Их цааз”-ыг батлав.
D. Батмөнх Даян хаан Монголыг захирав, Занабазарыг Анхдугаар Богдоор өргөмжлөв.
15. Дээд палеолитын дурсгал болох Ховд аймгийн Манхан сумын Хойд Цэнхэрийн агуйн хадны зургийг бүтээсэн аргаар нь хадны зургийн ямар төрөлд хамааруулдаг вэ?
А. Чимэглэл зураг В. Сийлмэл зураг С. Таталбар зураг D. Зосон зураг
16. Цэгийн оронд тохирох өгөгдлийг сонгоно уу?
Мезолитын үед хэмээх шинэ зэвсэг зохион бүтээсэн нь ан гөрөөний олзыг ихээр нэмэгдүүлжээ.
А. Сэлэм В. Жад С. Нум сум D. Бамбай
17. Монгол орны нутгаас неолитын үеийн бууц суурин, олдвор олдсон дурсгалт газар аль вэ?
А. Дорнод аймаг, Халх гол сумын Тамсагбулаг суурин
В. Ховд аймаг, Манхан сумын Хойд цэнхэрийн агуй
С. Баянхонгор аймаг, Баян-Овоо сумын Нарийн голын бууц суурин
D. Өвөрхангай аймаг, Хархорин сумын Мойлтын ам
18. 1206 онд Онон мөрний эхэнд Их хуралдай хуралдуулж, Их Монгол улсыг байгуулжээ. Их Монгол улс байгуулагдсаны 800 жилийн ой хэдэн онд болсон бэ?
А. 1996 онд В. 1906 онд
С. 2006 онд D. 2016 онд

19. 40.000 жилийн өмнө эртний хүмүүс ан агнуурын түүхий эдийг хаягдалгүй ашиглаж, яс, эврээр нь төрөл бүрийн багаж зэвсэг, гоёлын зүйлс, арьсаар нь хувцас хийх болсон нь чулуун зэвсгийн аль үед холбогдох вэ?
А. Доод палеолит В. Дунд палеолит С. Дээд палеолит D. Мезолит
20. Хүннү улсын үеэс эхлэлтэй засаг захиргааны аравт, зуут, мянгат, түмтийн тогтолцоог хожим ямар улс уламжлан авсан бэ?
А. Их Монгол улс В. Алтан улс С. Их Юань улс D. Иль хаант улс
21. Нирун (Жужан) улс мөхсөний дараа хүн ам нь Түрэгүүдэд шахагдаж, 3 хэсэг болж салав. Нэг хэсэг нь Эргүнэ гүнд очиж, нөгөө хэсэг нь Буйр нуурын сав газар нутаглажээ. Үлдсэн хэсэг нь ямар байдалтай оршиж байсан бэ?
А. Хүннү, Сяньби улсын харьяанд орсон
В. Тан, Когурё улсын харьяанд орсон
С. Перс, Зүүн Ром улсын харьяанд орсон
D. Түрэг, Уйгур улсын харьяанд орсон
22. Юань улсын үед хүн амаа 4 зэрэглэлд хувааж байв. Монгол хүнийг тэргүүнд тавьж, хоёрдугаарт ямар хүмүүс ордог байсан бэ?
А. Монгол хүн В. Өмнөд хятадын хүн
С. Умард хятадын хүн D. Өнгөт нүдтэн хүн
23. Цэгийн оронд тохирох нэрийг нөхнө үү.
Түмэдийн Алтан хан, Ордосын Хутагтай сэцэн хунтайжийн хамт 1577 онд Төвөдөөс ламыг залж, өөрсдөө тэргүүлэн Түмэд, Ордос нутагт шарын шашин дэлгэрүүлэв.
А. Содномжамц В. Намхайжамц С. Гармаа D. Занабазар
24. Монголын өвөг түүхийн үед холбогдох нээлтүүдийг зөв харгалзуулсан нь аль вэ?
а. Дунд палеолитын үе 1. Хэл яриа
b. Мезолитын үе 2. Шавар ваар
c. Неолитын үе 3. Гал
d. Дээд палеолитын үе 4. Буган хөшөө
e. Хүрэл, түрүү төмрийн үе 5. Нум сум
А. a-3 b-5 c-2 d-4 e-1 В. a-1 b-5 c-2 d-3 e-4
С. a-3 b-5 c-2 d-1 e-4 D. a-4 b-5 c-2 d-3 e-1
25. Дараах түүхэн үйл явцыг эртний улсуудтайн зөв харгалзуулсан нь аль вэ?
а. Елюй овгийн Амбагян хаан болов. 1. Нирун
b. 235 онд задрав. 2. Сяньби
c. 552 онд захиргаанд нь байсан Түрэгүүд бослого гаргав. 3. Уйгур
d. Өндөр тэрэгтний улс хэмээн нэрлэгдсэн. 4. Хүннү
e. 12 жилийн он тооллыг анх хэрэглэж байсан. 5. Хятан
А. a-2 b-3 c-1 d-5 e-4 В. a-5 b-2 c-1 d-3 e-4
С. a-5 b-4 c-1 d-3 e-2 D. a-2 b-5 c-1 d-3 e-4